

ДУНДАД ЭРТНИЙ ҮЕИЙН БУЛШИНД БОГ МАЛЫН НУРУУ ДАГАЛДУУЛАХ ЗАН ҮЙЛИЙГ МӨШГӨХ НЬ

Т.ТҮВШИНЖАРГАЛ

Монголын Үндэсний Музей
e-mail: ttuvshinjargal101@yahoo.com

Түлхүүр үг: Дундад эртний үеийн булш, бог малын нуруу, хөшөө чулуун дээрх дүрслэл, Судрын чуулган, Нирун, бөөгийн өмсгөл хэрэглэл

ТОВЧ АГУУЛГА: Дундад эртний булшинд нас барагчийн нуруун дор газар хонхойлгон ухаж бог малын нурууг байрлуулан хүнээ оршуулсан зан үйл түгээмэл тохиолддог. Энэхүү өгүүлэлд, уг зан үйлтэй холбогдож болох буган чулуу болон бусад хөшөө чулуун дээрх дүрслэлүүд, Рашид-ад-дины Судрын чуулганд тэмдэглэгдсэн Алунгоа эхийн ариун нуруугаар төрсөн гэх гурван хүү, тэдний овгийг нэрлэх Нирун (нуруу) хэмээх нэр, IV-VI зууны үед өнөөгийн Монгол нутгаар оршиж байсан Жоужань (Нирун) улсын нэр, мөн бөөгийн онгодын дүрийг илэрхийлдэг хэмээн үздэг өмсгөл, түүний онгодын унаа гэж төсөөлдөг хэнгэрэг, түүн дээрх дүрслэл зэргийн хооронд байж болох түүхэн залгамж холбоог авч үзлээ.

Эртний нүүдэлчдийн оршуулгын зан үйлд малын яс дагалдуулах явдал түгээмэл тохиолддог. Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Эгийн гол (Төрбат нар 2003: 119-127), Дорнод Монгол (Наваан нар 2004, 2005, 2007, 2008, 2009), (Батсайхан 2006), (Түмэн нар 2010, 2011), Өмнөговь (Түмэн нар 2008, 2010), Дорноговь (Эрдэнэболд нар, 2011) аймгуудад малтан судалсан дундад эртний үед холбогдуулан үзсэн нийт 133 булшны материалыг нэгтгэн харахад 64 булшнаас энэ үед холбогдох булшны гол шинж тэмдэг гэж судлаачдын үздэг бог малын шаант, нурууны яс илэрсэн байна. Эдгээр 64 булшны 34-өөс нь бог малын нурууны яс дангаараа илэрсэн ба 25 тохиолдолд нуруу болон шаантыг булшинд цуг дагалдуулан тавьжээ.

Нурууны яс гарсан тохиолдлуудыг тавьсан байрлалаар нь ажиглаж үзвэл 16 тохиолдолд хүний ууц, нуруу, аарцаг, дал, цээжний доороос буюу ар нуруун талаас илэрчээ (Зураг 1). Харин биеийн хажуу талаас гарсан 9 тохиолдол байна. Мөн цөөнгүй тохиолдолд нурууны яс илрэв гэх зэргээр тодорхой бус тэмдэглэгдсэн байгаа нь тухайн булшны тоногдсоны улмаас тодорхой байрлал заах боломжгүй байсан бололтой.

ДУНДАД ЭРТНИЙ ҮЕИЙН БУЛШИНД БОГ МАЛЫН НУРУУ ДАГАЛДУУЛАХ ЗАН ҮЙЛИЙН ТУХАЙ


Оршуулганд дагалдуулсан нурууны тооны хувьд нэг нугалмаар 2, хоёр нугалмаар 10, гурван нугалмаар 11, болон долоон нугалмаар 1 удаа (нурууг 3 болон 4 үеэр нас барагчийн зүүн болон баруун шууны хажуу талд тавьсан) (Зураг 2) илэрснээс үзвэл хоёр болон гурван үе нугалмууд давамгайлж байна. Есөн тохиолдолд дагалдуулан тавьсан нурууны тоог тодорхой дурдаагүй байна. Харин нас хүйсийн ялгаа ажиглагдахгүй байгаа ба бүс нутгийн ялгаа бага зэрэг ажиглагдаж байгаа ч цаашдын малтлага судалгаагаар тодруулах боломжтой юм. Тухайлбал: Эгийн голын булшинд 2 нугалам нуруу давамгайлж байхад Дорнод аймгийн Гурванзагал сумын Цагаан чулуут, Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Чандмань хар уул зэрэг бүлэг оршуулгатай газрын булшнуудад гурван нуруу тавиад дээрээс нь нас барагчийг тавьж оршуулсан тохиолдол давамгайлж байна. Өмнөговь аймгийн Номгон сумын Цагаантолгойн 4-р булшинд талийгаачийг оршуулахын өмнө нүхний доторх хадыг хонхойлгон ухаж бог малын гурван нугалам нурууг малд байрлах хэлбэрээр нь тавиад дээрээс нь хүнээ оршуулсан байсан бол (Түмэн нар 2008), (Зураг 3) Сонгино хайрхан уулын 2-р булшны нүхнээс бог малын 3 үе нуруунаас өөр хүний болон малын яс, эд өлгийн зүйл гараагүй (Наваан, Эрдэнэ 2008) байна. Эдгээрээс үзвэл эртний нүүдэлчид оршуулганд бог малын нурууг дагалдуулахдаа ихэвчлэн нас барагчийн нурууны тушаа, газар хонхойлгон ухаж байрлуулаад дээрээс нь хүнээ тавин оршуулдаг, дагалдуулах нурууны тоо зэргээс үзвэл энэ нь тогтсон зан үйл байсан бололтой.



Зураг 1. Нүүдэлчдийн оршуулганд малын нурууны ясны илэрсэн байрлал (булшны тоогоор)

Нүүдэлчдийн оршуулганд дагалдуулсан бог малын нурууны яс нь оршуулгын тахилын хоол хүнс дагалдуулан тавьдаг зан үйлээс өөр зориулалттай бололтой. Учир нь Пазырык, Хүннү, Түрэгийн үеийн булшнуудад тоног хэрэгсэлтэй нь дагалдуулан тавьсан хойлгын малнаас тахилын хоол хүнсийг тусад нь тавьж, хөмөг гаргах, хашлага гаргаж хийх, ваар саванд хийх, царан дээр тавих, хутга дагалдуулах зэргээр ялгасан байдаг бол дундад эртний булшинд далны ясны хамт

хутга дагалдуулан тавьсан тохиолдлууд (Наваан 1986:7-8), (Түмэн нар 2010/1/) цөөнгүй байна.



Зураг 2. Нүүдэлчдийн оршуулганд илэрсэн малын нугалам нурууны тоо (булшны тоогоор)

Өнөө хүртэл хуримтлагдсан судалгааны бүтээлүүдийг ажиглахад бог малын нуруу дагалдуулах зан үйлийн талаар ямар нэгэн санал, таамаглал судалгааны дүгнэлт хомс байна. Иймд уг зан үйлийн уламжлал, харилцаа холбоо, утга агуулга, билэгдэл зэргийг тодруулах үүднээс түүхэн бусад үеийн дурсгалуудад ажиглагддаг түүнтэй холбоотой байж болох зарим шинжүүдийг авч үзье.



Зураг 3. Өмнөговь аймаг, Номгон сум, Цагаантолгой. 4-р булш

Монгол орны төв болон баруун бүс нутагт олноор орших буган хөшөөний ар талд тагнай хээтэй таван талт дүрс байдгийг (Зураг 4) В.В.Волков (2002:17), Э.А.Новгородова нар бамбай юмуу эсвэл бөөгийн хувцсан дээр дүрсэлдэг хүний цээжний ясны дүрслэлтэй (Новгородова 1975, Баярсайхан 2007:24-аас дам ишлэв) адилтгасан байдаг. Харин судлаач Ж.Баярсайхан энэ дүрслэлийг бөөгийн хэнгэрэг, өмсгөл, мөн энеолитийн үеийн хадны зураг дахь дүрслэлүүдтэй тун төсөөтэй болохыг дурдан (2007:25), хүн болон амьтны биеийг ерөнхийлөн нэгтгэж төлөөлдөг нуруу хавирганы дүрслэл байж болох юм гэсэн санал дэвшүүлжээ. Мөн судлаач О.Пүрэв бөөгийн хэнгэргийн цохиурт байгаа тагнай хээ нь буган хөшөөнд элбэг тохиолддог үзэхэд эртний овог аймгуудын эрхэмлэн үздэг хээ нь бөөгийн шашнаар уламжлагдан ирсэн байж болох юм гэжээ (Пүрэв 1999:259).



А.

Б.

Зураг 4. Буган хөшөө.

А. Дөрвөн талаас харуулсан байдал. Б. Буган хөшөөний ар тал дахь дүрслэл



А.




Б.

Зураг 5. Дорнод, Гурванзагал сум, Хөцөөгийн хүн чулуун дээрх дүрслэл.

А. Хөшөөний нүүрэн тал, Б. Хөшөөний ар тал дахь дүрслэл.

Үүнтэй холбогдож болох дүрслэл хүн чулуун хөшөөн дээр байдгийг судлаачид тэмдэглэжээ. Тухайлбал: Дорнод аймгийн Гурванзагал сумын “Хөцөөгийн 2-р хүн чулууны ар талд өнцгөөр нь босгон дүрсэлсэн дөрвөлжин дотор, дугуй дүрснээс доош шулуун татсан байх ба энэ шулуун дээр хөндлөнгөөр таван богино зураасыг гаргасан” (Наваан нар., 2009:20) байна. (Зураг 5). Мөн Дорнод аймгийн Дашбалбар сумын Тарвагатын бэлчирийн хүн хөшөөний биеийн ар талд үүнтэй төстэй дүрслэл (Энхбат, Даваасүрэн 2010:60) илэрсэн. Хөцөөгийн хүн чулуун хөшөөг Х.Пэрлээ Хэнтий, Төв аймгийн нутгаар илрүүлэн судалсан хөшөөдтэй (1977:14-19) ижилсүүлж хүрэл зэвсгийн үед холбогдуулсан үзсэн ба түүн дээрх дүрслэлийн таван хөндлөн зураасыг нурууны дүрслэлтэй адилтгаж болохоор юм.

Эдгээрээс гадна ОХУ-ын Днепропетровск хотын ойролцоогоос олдсон “зарим судлаачид скифийн үед холбогдож болох талаар санал дэвшүүлсэн нэгэн



хүн чулуун хөшөөний ар талд хүний нуруу, хавиргыг нарийн сийлж дүрсэлсэн байдгийг Савинов, Челенова нар (1978:75) тэмдэглэсэн (Баярсайхан 2007:24-с дам ишлэв) (Зураг 6). Дундад эртний үеийн булшинд дагалдуулсан бог малын нуруу болон эдгээр хөшөөнүүд дэх дүрслэл нь биеийн ар талд байрлаж байгаагаараа ижилсэж байгаа нь ихээхэн сонирхол татаж байна.

Зураг 6. ОХУ-ын Днепропетровск хотын ойролцоогоос олдсон хүн чулуун хөшөөн дэх дүрслэл (Баярсайхан 2007).

Түүхийн сурвалжид үүнтэй холбогдож болох сурвалжийн мэдээ бас олдож байна. Тухайлбал, Судрын чуулганы *Монгол нирунчууд* гэж нэрлэгдсэн хүмүүсийн тухай хоёрдугаар бүлэгт: “Алунгоа нөхрөө үхсэнээс хойш гэрлийн туяанаас жирэмсэн болоод гурван хүү төрүүлжээ. Эдгээр хөвүүний овогт харъяалагддаг хүмүүсийг Нирун гэж нэрлэдэг. Нирун гэдэг нь Персээр Суло (нуруу) гэсэн үг болно. Тэд гэрлээс үүссэн болохыг энэ ариун нуруугаар зааж байдаг” (Рашид-ад-дин 2002:110, 164) гэх зэргээр тэмдэглэсэн буй. Судрын чуулганд *Нирун* гэсэн үг нь *нуруу* гэсэн утгатай болохыг олон удаа батлан дурдсан байх ба *нуруугаар төрсөн*, *ариун нуруу* гэх зэргээр дурдсанаас үзвэл нурууг ихээхэн хүндэтгэж үздэг байжээ.

Түүхч Г.Сүхбаатар IV-VI зууны үед өнөөгийн Монгол улсын нутгаар оршиж байсан, Хятад сурвалжид Жоужань хэмээн тэмдэглэгдсэн улсын нэрийн талаар гаргалгаа хийсэн байна. Жоужань гэдэг нэрийг нягтлан үзэж “язгуур монголчуудын угсаатны ерөнхий нэг нэр болох Нирун гэсэн нэр мөн байна. Нирун гэдэг нь тэр үед

уг нэрийг галиглан тэмдэглэсэн жоужань гэх хятад утга үсгүүдийн эртний дуудлагыг баримтлан нэхэн сэргээсэн худам монгол бичгийн ниругун гэдэг үг мөн бөгөөд орчин үеийн дуудлагаар нуруу (н) гэсэн үг юм” (Сүхбаатар 1992:164-176) хэмээн үзжээ. Нирун улсын талаар (330-555) Вэй шу-ийн 103-р бүлэг, Бэй ши-ийн 98-р бүлэгт: Тэд мэдлэггүй, мунхаг бөгөөд байдал нь тарианы өттэй төстэй учир жуаньжуань гэж хожим өөрчлөн нэрлэжээ (Сүхбаатар 1992:10-11,165).

Мөн Рашид-ад-дины судрын чуулганд: Алунгоа хатны үеэс гурван зуу орчим жилийн өмнө олон тооны салбар бий болж тэр салбар аймгийг Нирун гэж нэрлэдэг, тэдгээр нь нэр хүндтэй алдартай болсон (Рашид-ад-дин 2002:67) гэсэн мэдээ байна. Энд өгүүлснээр Алунгоагийн домгоос 300 орчим жилийн өмнө Нирун гэсэн нэр байсан байж таарч байна. Түүнээс гадна “Чингисийн өвөг дээдсийн улс, гүрнийг тодруулан, Чингис түүний ургийнхны овгийг салбарлуулсан, Добун баян, Алунгоагийн салбар мөчрийг, барагцаалан тоймловол энэ овог нь 400-гаад жил болсон байна. Учир нь хааны эрдэнэсийн санд байдаг тэдний онын бичгийн агуулгаас, мөн амьдрал үзэж хашир суусан ахмадуудын ярьдаг аман домгуудаас үзвэл доорхи байдал мэдэгдэж байна” (Рашид-ад-дин 2002:159) гэсэн нь Чингис хааны үеэс Алунгоа хатны үе хүртэлх он цагийг бодож гаргасан бололтой. “Нирун” гэж нэрлэгдсэн түрэг аймгуудын тухай дурсах нь: Тэд бол Алунгоа хатны сэргээсэн овгоос гаралтай монгол аймгуудын овог юм” (Рашид-ад-дин 2002:135). Дээр дурдсан хоёр мэдээний он цагийг нэмбэл Чингис хаанаас 700 орчим жилийн өмнө болж Нирун улсын (330-555) үетэй холбогдож байгаа ба сүүлийн мэдээнд нирун гэсэн нэрийг сэргээн хэрэглэсэн болохыг дурдсан байна. Эдгээрээс үзвэл Нирун улсын нэр, Алунгоа хатны нуруугаар төрсөн гэх гурван хүүгийн удмыг овоггосон Нирун хоёр нь залгамжилсан нэг нэр байж болж байна. Бөөгийн үзлээр нуруу нь амьтныг төлөөлөх гол яс учраас, тухайн үеийн овог аймгуудын гол хэсэг “*гол нуруу, голлох аймаг*” гэсэн утгатайгаар Нирун улсын нэрийг авч хожим нь Алунгоа хатны үед сэргээн хэрэглэсэн байж болох юм.

Дээр дурдсан археологийн хэрэглэгдхүүн болон сурвалжийн мэдээнүүдэд тулгуурлан дундад эртний үеийн оршуулганд бог малын нуруу дагалдуулах зан үйлийн талаар дараах хоёр таамаглалыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Дундад эртний үеийн оршуулганд дагалдуулсан бог малын нуруу нь Алунгоа хатны ариун нуруунаас төрсөн гэх гурван хүүг бэлгэдсэн байж болох юм. Нуруу дагалдуулсан оршуулга нь гурван хүүгийн овгийг нэрлэх Нирун овогтонд хамаарах хүмүүсийн оршуулга байж болох бөгөөд гурван нуруу нь тухайн овгийн дээд язгуур угсаатан болохыг илэрхийлсэн билэгдэл байж болох юм. Ийм малын ясан билэгдэл сүлдтэй угсаатан байсан байна. Тухайлбал, ОХУ-ын Сибирь хавиар нутагладаг Остек ясны гэж тэмдэглэгдсэн хүмүүс саяхан болтол далны ясыг дүрсэлсэн тамгатай байсан ба далны ясыг тахиж түүгээр сүлд тэмдгээ хийж байсан (Түдэв 2000:38-39) ажээ.

Алунгоа хатны домгийн талаар судлаачдын гаргасан олон тайлбар байдаг. У.Эрдэнэбат олон талын мэдээ баримт харьцуулан үзээд “Домогт “цэгээн шар хүн”-ээр төлөөлүүлэн Алунгоа хатны гэрт шөнө орж нөхцөж байсан хадмын талын хэн нэг хүнийг битүүхэн хэлсэн байж болзошгүй юм” (1997:49-50,54) хэмээн үзсэн нь нилээд магадлалтай хувилбар байж болохоор бөгөөд үүнийг археологич Г.Мэнэс (Мэнэс 2007:90-119) дэмжсэн байна. Харин А.Энхбат “Бодончар мунхагийн эцэг бол Малиг баягуд овогтон хүний дагуулж явсан хүү мөн бөгөөд тэр хөвгүүн Бөртгэ-чоно, Гуа-Маралын удмын хэн нэгэн сурвалжтан хүн” (2001:196) байсан хэмээн үзжээ.

Үүнтэй төстэй домог маш олон байдгийн (Сүхбаатар1992:142), (Мэнэс 2007) ихэнх нь хаад, хатад, язгууртан, шашны тэргүүн зэрэг нийгмийн дээд давхрааны хүмүүстэй холбогдолтой байна. Энэ нь нэг талаараа жирийн хүмүүсээс өөр хүн гэж энгийн ард олонд итгүүлэн, оюун санааг нь удирдах, тухайн хаад хатад зэрэг хүмүүсийг хүлээн зөвшөөрүүлэх, ингэснээр ард олныг нэгдмэл байлгаж удирдан дагуулах зорилготой байсан байж болох юм. Мөн шашны тэргүүнүүд өөрсдийн шашиндаа итгүүлэх, шашнаа дэлгэрүүлэх гэсэн бодлого, зорилготой холбоотой байж болно. Иймээс Алунгоа эхийн домог нь, дээрх эрдэмтдийн нягталснаар, Добу мэргэнээс хойш төрсөн гурван хөвүүд нь Бөртгэ чонын удмын хүний хүүхдүүд учир бусдаас онцгой, язгуур угсаат хүмүүс, харц хүмүүстэй зүйрлүүлж болохгүй хэмээн өгүүлсэн бололтой.

2. Энэхүү бог малын нуруу дагалдуулах зан үйл нь монгол нутаг дахь эртний түүхийн бүхий л цаг хугацаанд оршиж ирсэн бөөгийн шашинтай холбогдолтой зан үйл байж болох юм. Бөө мөргөлд “адгуусан амьтан хийгээд хүний биеийг гол нуруу, дөрвөн цул, 100 заадас, 80 судсаар холбогдож бүтсэн гэж үздэг ба бөөгийн онгодын унаа гэж үзэх хэнгэргэнд 4 гол хэсгүүдээ төлөөлүүлсэн зүйлсийг оруулж, бариул хөндлөн модон дээр тагнай хээ тавьж, тухайн амьтны гол нуруу хэмээдэг” (Пүрэв 1999:250-251,242) байна. Монголын үндэсний музейд хадгалагдаж буй бөөгийн хэнгэрэгний бариул модон дээрх дүрслэлүүд нь нурууны ясны дүрслэл байж болохоор харагдаж байна (Зураг 7). Мөн бөөгийн өмсгөл нь өөд болсон бөө хүний сүнсийг, өмсгөлийн дэвсгэр өнгө нь бөөд ирсэн онгодын зүс царайг илэрхийлдэг байна (Пүрэв 1999:176,190-191). Эдгээрээс үзвэл бөөгийн өмсгөл дээр онгодын биеийг илэрхийлж нуруу, хавирга болон араг ясыг, харин хэнгэрэгний бариул гэх мэт зүйлс дээр онгодын унааг илэрхийлж амьтны гол нурууг төлөөлүүлэн тагнай хээг дүрсэлдэг бололтой.

Дундад эртний оршуулганд бог малын нурууг малд байрлах хэлбэрээр буюу арын сэртэнг дээш харуулан нас барагчийн ар нуруун доор байрлуулсан тохиолдол давамгайлж байна. Энэ нь нас барагчийг хэвтээгээр нь ачсан хэлбэртэй харагдаж буй юм. Монгол бөөгийн шашинд, халин одогсдын сүнснүүд харанхуйн оронд дэгдээд тэндээс зөвхөн бөө хүний сүнс онгод болон нартад эргэж ирдэг (Пүрэв 1999:112,321) гэж үздэг бөгөөд хандгай, буга, согоо, баавгай, чоно, морь, ямаа зэрэг амьтад нь онгодын унаа болдог байна. (Пүрэв 1999:246,256). Өөрөөр хэлбэл нарт

ертөнц болон харанхуйн орон хоёрын дунд онгодын унаа болж чөлөөтэй явдаг дээрх амьтад нь тухайн нас барагчийн сүнсийг харанхуйн оронд хүргэх унаа болдог гэсэн бөөгийн зан үйл, ойлголт байдаг аж. Иймээс эртний нүүдэлчдийн оршуулганд нуруу дагалдуулах зан үйлээр бөөгийн онгодын унаа гэж үздэг дээрх амьтдыг билэгдэн илэрхийлсэн байж болох юм.



Зураг 7. МҮМ-н сан хөмрөгт байгаа бөөгийн хэнгэргийн бариул дээрх дүрслэлүүд

Талархал

Энэхүү өгүүллийг бичихэд үнэтэй зөвлөгөөгөө харамгүй хайрласан багш МУИС-НШУС-ийн Археологи-антропологийн тэнхимийн багш М.Эрдэнэ (Ph.D) болон МҮМ-н Судалгаа, үзүүлэг зохион байгуулалтын албаны дарга Ж.Баярсайхан (МА) нарт талархал илэрхийлье.

Ном зүй

- Батсайхан З.*, 2006. Дорнод Монгол 2005-2006, хээрийн шинжилгээний тайлан. МУИС-НШУС, Археологи-Антропологийн тэнхимийн ГБСХ.
- Баярсайхан Ж.*, 2005. Буган чулуун хөшөөн дэх дүрслэлийн утгыг хайхуй. Acta historica, Tomus VI, Fasc. 2. УБ. х. 24-27.
- Волков В В.*, 2002. Оленные камни Монголии. Москва.
- Мэнэс Г.*, 2007. Нүүдэлчдийн хоёр төрийн хаадын уг эхийн домгуудын үнэн магад түүхийг нягтлах нь. // Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology. Volume 3 № 1(287), УБ. х. 90-119.
- Наваан Д.*, 1986. Дундад зууны үеийн монголчуудын оршуулах зан үйлийг судлах асуудалд. Археологийн судлал. Tomus 11. Fasc 1. УБ. х. 3 -10.
- Наваан Д, Түмэн Д, Эрдэнэ М.*, 2004. Дорнод Монгол 2003-2004, хээрийн шинжилгээний тайлан. МУИС – НШУС, Археологи-Антропологийн тэнхимийн ГБСХ.
- Наваан Д, Түмэн Д, Эрдэнэ М.*, 2005. Дорнод Монгол 2004-2005, хээрийн шинжилгээний тайлан. МУИС - НШУС, Археологи-Антропологийн тэнхимийн ГБСХ.
- Наваан Д, Түмэн Д, Эрдэнэ М, Өлзийбаяр С.*, 2007. Дорнод Монгол 2006-2007, хээрийн шинжилгээний тайлан. МУИС-НШУС, Археологи-Антропологийн тэнхимийн ГБСХ.
- Наваан Д, Түмэн Д, Эрдэнэ М, Хатанбаатар Д.*, 2008. Дорнод Монгол 2007-2008, хээрийн шинжилгээний тайлан. МУИС-НШУС, Археологи-Антропологийн тэнхимийн ГБСХ.

- Наваан Д., Эрдэнэ М., 2008.* Археологийн танилцах дадлагын тайлан. МУИС-НШУС, Археологи-Антропологийн тэнхмийн ГБСХ.
- Наваан Д, Түмэн Д, Эрдэнэ М, Хатанбаатар Д, Анхсанаа Г., 2009.* Дорнод Монгол 2008-2009, хээрийн шинжилгээний тайлан. МУИС-НШУС, Археологи-Антропологийн тэнхмийн ГБСХ.
- Наваан Д, Түмэн Д, Эрдэнэ М, Хатанбаатар Д, Анхсанаа Г., 2009.* “Дорнод монгол” төслийн хүрээнд 2009 онд хийж гүйцэтгэсэн археологийн судалгаа. Mongolian journal of Anthropology, Archaeology and Ethnology. Volume 5 No.1(344), УБ. 1-53.
- Пүрэв О., 1999.* Монгол бөөгийн шашин. УБ
- Пэрлээ Х., 1977.* Хүн чулуун хөшөөний үүсэл хувьслыг судлах тухай. УБ. Археологийн судлал. Tomus VII. Fasc 2.
- Рашид-ад-дин., Судрын чуулган (Сүрэнхорлоогийн орчуулга), 2002.* УБ.
- Сүхбаатар Г., 1992.* Монгол нирун улс. УБ.
- Төрбат Ц, Амартүвшин Ч, Эрдэнэбат У., 2003.* Эгийн голын сав нутаг дахь археологийн дурсгалууд. УБ.
- Түдэв Л., 2000.* Далны толь, УБ.
- Түмэн Д, Эрдэнэ М, Хатанбаатар Д, Ванчигдаш Ч, Анхсанаа Г., 2008.* Өмнөговь аймгийн нутагт хийсэн хээрийн шинжилгээний авран хамгаалах экспедицийн тайлан. МУИС-НШУС, Археологи-Антропологийн тэнхмийн ГБСХ.
- Түмэн Д, Эрдэнэ М, Хатанбаатар Д, Ванчигдаш Ч., 2010.* Өмнөговь аймгийн нутагт хийсэн хээрийн шинжилгээний авран хамгаалах экспедицийн тайлан. МУИС-НШУС, Археологи-Антропологийн тэнхмийн ГБСХ.
- Түмэн Д, Эрдэнэ М, Хатанбаатар Д, Ванчигдаш Ч, Анхсанаа Г., 2010.* Дорнод Монгол 2009-2010, хээрийн шинжилгээний тайлан. МУИС-НШУС, Археологи-Антропологийн тэнхмийн ГБСХ.
- Түмэн Д, Эрдэнэ М, Хатанбаатар Д, Анхсанаа Г., 2011.* Дорнод Монгол 2010-2011, хээрийн шинжилгээний тайлан. МУИС-НШУС, Археологи-Антропологийн тэнхмийн ГБСХ.
- Энхбат А., 2001.* Бодончар богдын удмыг мөшгөхүй. Угсаатан судлал, Tomus XIII. Fasc.22, УБ. 190-196.
- Эрдэнэбат У., 1997.* “Монголын нууц товчоо”-ны Алун гоа эхийн домгийн учир. УБ.
- Эрдэнэболд Л, Хатанбаатар Д, Ванчигдаш Ч, Уртнасан Э., 2011.* Дорноговь, Дэлгэрэх сум Чандмань хар уул. Авран хамгаалах экспедицийн тайлан. ШУТИС-НТС-ийн ГБСХ.

SUMMARY

T. Tuvshinjargal

ASSOCIATION OF ANIMAL BACKBONE IN THE BURIAL OF EARLY MEDIEVAL NOMADS OF MONGOLIA

In this article author discusses about one of the common ritual of the early medieval nomads of Mongolia – associating animal vertebrae in the burial. The author talks of possible historical relationship of this ritual with the analogous images on the deer stone, stone-man and shaman drum, and ethnonym ‘Nirun’ – the name of the Alun-Goo’s three sons’ tribe and a tribe existed in 4th - 6th centuries in Mongolia.